

ТАЙЛАН

Шарга сумд “нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулсан тухай
2017.10.24

Баянгол

Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоолын дагуу төрийн байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөр”-ийг сумд 2017.10.20-ны өдөр зохион байгууллаа. Нээлттэй хаалганы өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай сумын Засаг даргын 2017.10.17-ны өдрийн 01\369 тоот албан бичгийг байгууллагуудад хүргүүлж нэгдсэн байдлаар Соёлын төвд зохион байгууллаа. “Нээлттэй хаалганы өдөр”-т сумын төсөвт 5 байгууллага өөрийн үйл ажиллагааг самбар, үзүүлэн, фото зураг, сургалт, хоол амталгаа, нээлттэй хичээл, эцэг эхийн уулзалт зэрэг байдлаар иргэд хөдөлмөрчдөд танилцууллаа. Мөн ЗДТГ-аас энэ онд хэрэгжсэн томоохон арга хэмжээнүүд, шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар электрон хичээлийг үзүүллээ. Иргэдийг оролцоог хангах үүднээс байгууллагууддаа 4 хорооллын иргэдийг хариуцуулж цуглуулсан.



Мөн ЗДТГ-ын Нээлттэй хаалганы өдрийг үйл ажиллагааны төлөвлөгөө, үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу баг бүрт зохион байгуулсан.

6 сарын 29-нд Сондуулт багт \42 хүн хамрагдсан.\

6 сарын 30-нд Хамтын хүч багт \83 хүн хамрагдсан.\

9 сарын 25-нд Улаантуг багт \45 хүн хамрагдсан.\

10 сарын 04-нд Баянгол багийн Дээд голд \27 хүн хамрагдсан.\

10 сарын 06-нд Баянгол багийн Заг овооны гүүр \19 хүн хамрагдсан.\

10 сарын 20-нд Сумын төвд \120 хүн хамрагдсан\ тус тус ажиллаж үйл ажиллагаа сурталчилж төрийн захиргааны үйлчилгээг хүргэсэн.

Сургууль: Сургуулийн “Нээлттэй хаалганы өдөр”-ийг 10 сарын 20-нд зохион байгуулах зарыг эцэг эх, иргэд хөдөлмөрчдөд хүргэн, 2017 оны 10 сарын 20-ны өдрийн 8:30 минутаас 11:00 цагийн хооронд судлагдахуун бүрийн хичээл дээр эцэг эхчүүдийг оролцуулав.



11:00 цагт сургуулийн эцэг эхийн хурлыг зохион байгууллаа. Нийт 40 эцэг эх хамрагдсан. Хурлаар дараах асуудлуудыг авч хэлэлцлээ.

- Сургуулийн захирал М.Золбаяр сургуулийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл
- Дунд ангийн сургалтын менежер Д.Нарантуяа сургалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл
- Эцэг эх, иргэдийн асуулт, санал хүсэлтийг хүлээн авч хариултыг өгч, хэлэлцэж, ярилцлаа.

Эцэг эх, иргэдээр үдийн цайны гурилан бүтээгдэхүүн, хоолонд амталгаа хийлгэж, санал хүсэлтийг хүлээн авлаа.



Хүүхдийн цэцэрлэг: Байгууллага сурталчлах нээлттэй хаалганы өдрөөр хоолны амталгаа хийлгэхээр 14 нэр төрлийн хоол хийж иргэдэд амтлуулж иргэдээс нийт 6 санал бичгээр ирсэн.



Амаар болон шийдвэрлэх санал хүсэлт ирээгүй байна. Мөн бага бүлгийн эцэг эхчүүдэд хурал хийж хүүхдүүдийн бүтээлтэй танилцуулж, гар угаах дарааллын тараах материал 19 эцэг эхэд тарааж зөвлөгөө өгч ажилласан байна.

Ахлахбүлэг хүүхдүүдийнхээ дунд АХА тэмцээн явуулж Ц.Отгонцэцэг түрүүлж удаах байранд нь Ш.Анхмаа , А.Золзаяа нар орж оюун ухаан авхаалж самбаагаа дайчлан оролцож 25 эцэг эх үзэж сонирхлоо.



Соёлын төв: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97-р зарлиг, Засгийн газрын 190 дүгээр тогтоолоор жил бүр зохион байгуулдаг төрийн байгууллагын нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулах ажлын хүрээнд энэ сарын 20-ны өдөр төрийн байгууллагууд хамтран зохион байгууллаа. Байгууллагынхаа үйл ажиллагааг иргэдэд танилцуулан номын сан, орон нутаг сурталчлах танхим болон бусад үйл ажиллагааг танилцуулан ажиллалаа.



Номын сан, музей, соёл урлаг, аж ахуй гэсэн 4 төрлөөр мэдээллийг бэлтгэн самбарт байрлуулан иргэдэд хүргэж ажилласан.

Сумын хэмжээнд төрийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдрийн арга хэмжээнд 5 байгууллага үйл ажиллагаагаа сурталчилж давхардсан тоогоор 424 иргэн оролцож 46 санал хүсэлтийг ирүүлсэн байна. Шийдвэрлэж өгөх болон хариу хүссэн өргөдөл гомдол ирээгүй. Бүгд зөвлөмж өгсөн, санал байсан.

ХЯНАСАН:ЗАСАГ ДАРГА

Р.ОЮУНЧИМЭГ

ТАЙЛАН БИЧСЭН:ДАШБХ МЭРГЭЖИЛТЭН

Д.ОНЧИМЭГ

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АРХИВТ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН
БАРИМТЫН ЖАГСААЛТ

2017.10.25

Шарга, Баянгол

№	Хүлээлгэн өгсөн баримтын нэр	Тоо ширхэг	Хүлээлгэн өгсөн	Хүлээн авсан
1	Сумын 90 Жилийн ойн ном	1 ш		

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АРХИВТ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН
БАРИМТЫН ЖАГСААЛТ

2017.10.25

Шарга, Баянгол

№	Хүлээлгэн өгсөн баримтын нэр	Тоо ширхэг	Хүлээлгэн өгсөн	Хүлээн авсан
1	Сумын 90 Жилийн ойн ном	1 ш		